

МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/307

Номгон

Газар нэмж эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 116 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий газрын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төрийн байгууллагуудад газрыг нэмж эзэмшүүлж, хавсралтаар баталсугай.

2. Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

521010783

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын  
13-ны өдрийн А/307 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР НЭМЖ ЭЗЭМШИЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

№	Эзэмшигчийн мэдээлэл		Эзэмшигчийн газрын мэдээлэл				
	Нэр	Регистрийн дугаар	Талбайн хэмжээ /м2/	Нэмэгдэж буй талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ /м2/	Хаяг	Зориулалт
1	Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ны хангайн бүсийн салбар	2685221	5814	2535	8349	Номгон 1-р баг, Нисэхийн-2 гудамж, 200 тоот	Дэд станц
2	Аймгийн Татварын хэлтэс	9007482	1000	955	1955	Цахир 7-р баг, Эрхчөлөөний-2 гудамж, 211 тоот	Албан контор
3	Цэвэр хот ОНӨААТҮГ	8147132	2497	1325	3822	Номгон 1-р баг, Нисэхийн-3 гудамж, 300а тоот	Авто тээврийн үйлчилгээний барилга байгууламж

